

ӨЛЗИЙТ СУМЫН 2022-2023 ОНЫ МАЛ АЖ АХУЙН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2022-10-31

Өлзийт

Тус сум нь 179,9 мянган га нутаг дэвсгэртэй , Засаг захиргааны 4 багийн 2318 хүн амтай, үүнээс эрэгтэй-1247, эмэгтэй -1193 , хүүхэд-885, 934 малчин, 729 өрхтэй үүнээс 624 малчин өрх, мал бүхий 45 өрх байна.

2022-2023 оны мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахдаа Монгол улсын Засгийн газрын 277 дугаар тогтоолоор хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг хангах нэгдсэн арга хэмжээ, аймгийн Засаг даргын өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөөнд үндэслэн сумын 2022-2023 оны Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөө , арга хэмжээг боловсруулан сумын Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн а/71 тоот захирамжаар батлуулан ажиллаж байна.

2021 оны жилийн эцсийн мал тооллогоор 167,850 толгой мал тоолуулсанаас адуу-13055, үхэр-6599 , тэмээ-179, хонь-98719, ямаа-48733 тоолуулж, шинээр 71942 төл нэмэгдэж, хүнсний хэрэгцээнд болон зах зээл зарж борлуулах 27608 толгой мал зарцуулж, эцсийн байдлаар 211619 мал, хонин толгойд шилжүүлснээр 275,267 толгой мал өвөлжиж, хаваржих төлөвтэй байна.

Тус сумын хувьд зуншлага харилцан адилгүй нутгийн хойд хэсгээр ургамлын гарц дунд зэрэг төв болон нутгийн урьд хэсгээр гандуу, гантай байсан, зуны саруудад Сант, Баянгол, Төгрөг , Гучин-Ус сумын 60 гаруй өрх зусаж бэлчээр талхлагдсаны дээр бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн 34,3%-500 хувиас их буюу өвөл –хаврын бэлчээрийн даац нутгийн 10 гаруй хувьд хүрэлцээтэй байхаар, харин 90 гаруй хэтрээд байгаа тул сумын хэмжээнд одоогийн байдлаар 6 аймгийн 22 сумын нутаг буюу Булган аймгийн Гурван булаг, Дашинчилэн, Баяннуур, Бүрэг хангай, Төв аймгийн Жаргалант, Цээл, Сүмбэр, Зүүн хараа, Заамар, Баянцогт, Баянхангай, Баянчандмань, Атар, Архустай, Бага хангай, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Орхон, Хөтөл, Дорнодын аймгийн Дашбалбар, Хэнтий аймгийн Дархан, Даланжаргалан аймаг, суманд нийт 99 өрхийн -15,8 хувь, 383- иргэн нийт хүн амын -16 хувь үүнээс эрэгтэй 192 , эмэгтэй-191, 0-5 насны хүүхэд -41, өндөр настан -23, хөгжлийн бэрхшээлтэй-5, жирэмсэн-2, архаг суурь өвчинтэй-45, Нийт мал 56,460 толгой мал, үүнээс бод-7709, бог-48,751 оторлох бөгөөд нийт малчин өрхийн 15,8 хувь, нийт мал сүргийн 33,6 хувь отроор нүүдэллэхээр малчид бэлтгэлээ хангасан байна.

Өнөөдрийн байдлаар Булган аймгийн Дашинчилэн, Бүрэгхангай, Сэлэнгэ аймгийн Орхон, Орхон туул, Төв аймгийн Баянчандмань, Зүүн хараа, Атар, Жаргалант, Архустай, Дорноговь аймгийн Даланжаргалан зэрэг суманд 64 өрхийн 8,259 бод, 24,174 бог нийт 32,433 толгой мал отроор нүүдэллэн хүрээд байгаа бол нийт оторлох өрхийн 64,6 хувийг эзэлж байна.

Малчин өрхүүдийн хүн малын эрүүл мэндэд анхаарч мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлж- Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд: Баян ханхал, Баяндалайн баялаг, Зос хангай мал эмнэлгүүд суманд мал эмнэлэгийн үйл ажиллагаа хийж хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар ДХХ(доторын халдварт хордлого)-38,817 толгой хонь, Цусан халдвар-

1,150 үхэр, Шүлхий-5,437 үхэр, бог-20,0, БММ-26,000 бог, Шөвөг яр-2,395 ишиг, туулгалт-80 нохой, 18,200 үхэр, 71,905 бог, үхрийн шүлхийн вакцин -8900 толгой малд тус тус хийгдэж вакцин тарилга туулгалтанд бүрэн хамруулан малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийж, малын эмчээр баталгаажуулан, заавар зөвлөмжөөр ханган ажиллаж,

Сумын хэмжээнд нийт 693 хээлтүүлэгч бог малд ангилан ялгалт хийж ээмэгжүүлэн, цусны шинэжилгээ авч шинэжилгээ хариу бүгд сөрөг буюу өвчлөл илрээгүй байна.

Суманд өвөлжих айл өрхүүд өвөлжилт хаваржилтын бэлтгэлээ хангаж малчин өрхүүд өвс, ногоон тэжээл-934 тн, гарын тэжээл 125 тн, хужир шүү-340 тн, сумын төвд 3 тэжээлийн агуулахын нөөцөд 80 тн өвс, ногоон тэжээл төвлөрүүлэхээс нийт 96,2 тонныг сумын Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгжүүд бэлтгэсэн бол 1, 4 дүгээр багийн тэжээлийн фондонд өвс нөөцөлсөн байна .

Сумын хэмжээнд нийт 95 хүн малын ундны усны худагтай ба 6-7 малчин өрхөд 1 худаг ноогдож, 1 худагт -1700 орчим мал ундлахаар байна.

Энэ онд инженерийн хийцтэй гүн өрмийн худаг Улсын төсвийн хөрөнгөөр- 1 , Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр- 2, мал хамгаалах сангийн хөрөнгөөр - 1 нийт 4 худаг гаргаж хүн амын болон бэлчээрийн усан хангамж нэмэгдүүлэн , малчин өрхүүд хашаа саравч дулаалах, худаг усны бэлэн байдал 100 хувь хангагдсан байна.

Малчид дунд болон дундаас доош тарга хүч мал сүргийг зах зээлд худалдан борлуулах, өвс тэжээл худалдан авахад зарцуулж нийт 27608 толгой мал хэрэгцээлэх ба нийт мал сүргийн 17 хувийг эзэлж байна.

Суманд “АЛТАН НАМАР 2022” үзэсгэлэн худалдаан 2022 оны 09 сарын 26ны өдөр зохион байгуулагдаж иргэд малчид идэвхтэй оролцлоо. Мөн Өвөрхангай аймаг “НАМРЫН НОГООН ӨДРҮҮД-2022” үзэсгэлэн худалдаа 09 сарын 25-30-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө.

Төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг 90 хувьтай хангасан, гал тогоо бүхий байгууллагуудын хоол хүнсний хэрэгцээг хангахдаа Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын гурил будаа-, төмс хүнсний ногоо, сүү аарцыг Баян Түмэн ХХК , Борхын Цагаан-Овоо ХХК нь мах нийлүүлж байна.

Жилдээ мах-3,5 тн, төмс хүнсний ногоо-4,3 тн, гурил будаа-17,4 тн, сүү аарц-3,4 тн нөөц бүрдүүлэн, гурил будаанаас бусад хүнсээ 100 хувь өөрийн сумын бүтээгдэхүүнээр ханган нийлүүлж хэвшээд байгаа юм.

Төсөвт болон төрийн бус байгууллагууд нэгдсэн халаалтанд холбогдсон ба дулаан нийлүүлэгч “Илч Кассандра” ХХК- нь нүүрс татан авалт хийж, 30 хоногийн нөөц бүрдүүлэн ажиллаж байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын явц 84,9 хувьтай байна .